

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/153/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p> | <p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261663 Цахим хаяг: Tsogbayara@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Ариунжаргал Утас: 261740 Цахим хаяг: Ariunjargalb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Өсөхжаргал Утас: 261740 Цахим хаяг: Usukhjargalg@audit.gov.mn</p> <p>Аудитор: Д.Номингуа Утас: 261740 Цахим хаяг: Nominguad@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-----------|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 10 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 11 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 13 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 14 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..... | 14 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 15 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 16 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 16 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 18 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт | 18 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл..... | 18 |
| 3.5.3 Нэмэлт төсөв..... | 20 |
| 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл..... | 21 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 23 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 23 |
| 4.2 Материаллаг байдал | 23 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 23 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 23 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 23 |
| 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд | 24 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 25 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 25 |
| 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | 26 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 26 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 28 |
| 5.1 Албан шаардлага | 28 |
| 5.3 Зөвлөмж | 30 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 32 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ГБХНХЯ | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/364

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 156,309.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Нэмэлт төсвөөс нийт 15,020.4 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн;
- Ахмадын сангийн батлагдсан төсвийг "Ахмадын сан"-д төвлөрүүлэлгүй 13,212.9 мянган төгрөгийг зарцуулсан;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 14,385.8 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийсэн, 7,728.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 14.4.6, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай журмын 3 дугаар зүйлийн 3.1, Нийгмийн даатгалын

ерөнхий газрын даргын баталсан "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах" журмын 2, 5.1, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "ангилал", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/131, А /146 дугаар тушаалуудын дагуу салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж, төсөл арга хэмжээний хүрээнд тус газарт нийт 728,612.5 мянган төгрөгийн үнэ бүхий серверийн тоног төхөөрөмж, 114,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, тоног төхөөрөмжийг тус тус хуваарилсныг үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгасан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийгмийн даатгалын мэдээллийн Sicos системийг салбарын хэмжээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан тус системийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр бүрэн хүлээн авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хөрөнгөд 2,759,939.2 мянган төгрөгийн өртөг бүхий программ, хангамжийг бүртгэн, цаашид системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хариуцахаар шийдвэрлэжээ.

Тайлант онд тус системийн сайжруулалт, хөгжүүлэлттэй холбоотой лиценз худалдан авахад нийт 2,707,800.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаас зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Жендерийн салбар зөвлөлийг" шинэчлэн байгуулах тухай" А/284 дүгээр тушаалаар "Жендерийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийг, жендерийн салбар зөвлөлийн дарга "Нийгмийн даатгалын салбарт жендерийн тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх жендерийн салбар зөвлөлийн 2025-2026 оны төлөвлөгөө"-г тус тус баталжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------|---|--------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 130,366,617.92 | 91,979,819.65 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 303,337.15 | - |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 303,337.15 | - |
| 31210 | Төгрөг | 303,337.15 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 303,337.15 | - |
| 33 | АВЛАГА | 734,180.00 | 734,180.00 |
| 33500 | Бусад авлага | 734,180.00 | 734,180.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 19,710.00 | 19,710.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 714,470.00 | 714,470.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 129,329,100.77 | 91,245,639.65 |
| 35400 | Хангамжийн материал | 129,329,100.77 | 91,245,639.65 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 8,775,359.99 | 12,702,123.49 |
| 35420 | Аж ахуйн материал | 55,130,321.78 | 61,684,706.16 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 12,198,960.00 | 12,248,860.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 53,224,459.00 | 4,609,950.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,262,584,137.34 | 8,488,324,883.08 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,262,584,137.34 | 8,488,324,883.08 |
| 39200 | Биет хөрөнгө | 5,202,304,393.44 | 5,826,925,144.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,031,944,551.54 | 5,031,944,551.54 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (474,649,925.65) | (556,216,658.05) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 89,520,000.00 | 62,070,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (40,077,500.00) | (54,222,500.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 852,134,628.07 | 1,557,588,533.49 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (439,496,767.60) | (400,915,966.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 501,800,840.93 | 334,776,529.54 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (318,871,433.85) | (148,099,345.79) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 60,279,743.90 | 2,661,399,738.91 |
| 39301 | Програм хангамж | 33,808,879.60 | 2,727,315,560.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (33,336,555.70) | (150,433,333.09) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 161,914,425.00 | 84,517,512.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (102,107,005.00) | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 5,392,950,755.26 | 8,580,304,702.73 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 454,085.96 | 205,442.16 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 454,085.96 | 205,442.16 |
| 41300 | Өглөг | 454,085.96 | 205,442.16 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 389,211.36 | 155,442.16 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 14,874.60 | - |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 50,000.00 | 50,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,392,496,669.30 | 8,580,099,260.57 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,392,496,669.30 | 8,580,099,260.57 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 2,130,919,957.98 | 2,130,919,957.98 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 2,130,919,957.98 | 2,130,919,957.98 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,573,949,919.60 | 4,761,552,510.87 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (3,837,189,558.97) | 1,573,949,919.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 5,411,139,478.57 | 3,187,602,591.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,687,626,791.72 | 1,687,626,791.72 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 5,392,950,755.26 | 8,580,304,702.73 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|---|-------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 11,601,788,248.71 | 9,704,982,339.12 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,712,433,754.71 | 9,704,982,339.12 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,712,433,754.71 | 1,106,346,712.12 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 33,568,312.00 | 31,128,192.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 33,568,312.00 | 31,128,192.00 |
| 120009 | Бусад орлого | 1,927,913.40 | 945,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 5,551,061,718.14 | 1,072,673,120.12 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 125,875,811.17 | 1,600,400.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 8,598,635,627.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 8,598,635,627.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 8,517,661,017.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 8,517,661,017.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 80,974,610.00 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 80,974,610.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,889,354,494.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,822,130,644.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,822,130,644.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 67,223,850.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 67,223,850.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,113,124,597.30 | 6,400,951,752.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,113,124,597.30 | 6,400,951,752.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,046,481,175.27 | 5,477,547,330.55 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,457,559,585.07 | 3,920,802,370.86 |
| 210101 | Үндсэн цалин | 1,795,319,755.83 | 1,945,223,121.35 |
| 210102 | Нэмэгдэл | 665,938,193.47 | 919,464,593.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 388,392,190.00 | 561,735,000.00 |
| 210104 | Урамшуулал | 587,909,445.77 | 494,379,656.17 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,000,000.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 413,750,555.18 | 466,203,298.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 288,154,556.97 | 325,868,976.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 33,874,851.71 | 39,021,338.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 17,000,589.24 | 19,592,729.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 14,622,210.68 | 16,130,328.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 60,098,346.58 | 65,589,925.38 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 51,027,511.24 | 51,949,717.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,260,448.91 | 31,611,762.83 |
| 210302 | Түлш, халаалт | 13,739,777.33 | 14,041,973.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,027,285.00 | 6,295,981.23 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 139,008,199.54 | 170,421,577.18 |
| 210401 | Бичиг хэрэг | 43,688,902.00 | 29,816,236.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,339,265.00 | 2,681,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,389,099.54 | 24,852,705.94 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 20,558,699.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,785,000.00 | 1,440,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 68,805,933.00 | 70,753,976.74 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 20,318,859.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 117,387,633.00 | 19,145,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 38,320,386.00 | 1,351,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 79,067,247.00 | 17,794,050.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 276,313,396.00 | 151,564,450.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 276,313,396.00 | 151,564,450.00 |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|---------|---|------------------|------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 193,745,251.36 | 168,570,225.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 187,432,029.00 | 155,246,154.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,704,930.00 | 3,312,836.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 363,245.00 | 1,228,135.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,662,000.00 | 4,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,442,794.00 | 459,690.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 80,453.36 | 159,510.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,059,800.00 | 3,297,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 397,689,043.88 | 528,890,441.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,198,634.00 | 945,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 113,098,707.00 | 11,264,282.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 275,391,702.88 | 516,681,159.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,066,643,422.03 | 923,404,422.24 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 743,695,671.59 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 743,695,671.59 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 743,695,671.59 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 743,695,671.59 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 233,800,546.06 | 179,405,413.50 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 119,886,201.73 | 57,763,997.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 113,914,344.33 | 121,641,416.50 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 832,842,875.97 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 832,667,875.97 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 175,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 303,337.15 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 303,337.15 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 5,488,663,651.41 | 3,304,030,586.33 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 77,524,172.84 | 116,427,995.06 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 21,249,032.84 | 73,711,815.06 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 56,275,140.00 | 42,716,180.00 |
| VII | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (77,524,172.84) | (116,427,995.06) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 5,411,139,478.57 | 3,187,602,591.27 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|---|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 5,947,147,927.40 | 8,630,708,819.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 55,959,233.40 | 8,630,708,819.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 55,959,233.40 | 32,073,192.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 55,959,233.40 | 31,128,192.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,762,750.00 | 31,128,192.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 196,483.40 | - |
| 120009 | Бусад орлого | - | 945,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 8,598,635,627.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 8,598,635,627.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 8,517,661,017.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 8,517,661,017.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 80,974,610.00 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 80,974,610.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,891,188,694.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 5,822,130,644.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 5,822,130,644.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 69,058,050.00 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 69,058,050.00 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,920,771,730.25 | 5,889,151,956.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,920,771,730.25 | 5,889,151,956.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,831,866,100.22 | 4,965,747,533.91 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,457,236,217.90 | 3,920,973,380.06 |
| 210101 | Үндсэн цалин | 1,675,723,927.15 | 1,975,987,715.34 |
| 210102 | Нэмэгдэл | 820,886,439.55 | 932,128,699.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 390,034,730.06 | 524,743,779.34 |
| 210104 | Урамшуулал | 550,591,121.14 | 488,113,185.78 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,000,000.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 413,687,795.18 | 466,266,058.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 289,167,016.19 | 325,931,736.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 33,162,727.02 | 39,021,338.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 16,938,532.65 | 19,592,729.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 14,570,149.09 | 16,130,328.56 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 59,849,370.23 | 65,589,925.38 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 51,027,511.24 | 51,949,717.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,260,448.91 | 31,611,762.83 |
| 210302 | Түлш, халаалт | 13,739,777.33 | 14,041,973.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,027,285.00 | 6,295,981.23 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 138,000,754.54 | 151,856,640.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 48,520,890.00 | 31,590,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,339,265.00 | 2,681,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,389,099.54 | 24,852,705.94 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 57,354,210.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,785,000.00 | 1,440,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 62,966,500.00 | 33,937,724.72 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 139,187,633.00 | 26,134,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 60,120,386.00 | 319,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 79,067,247.00 | 25,814,650.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 276,313,396.00 | 151,564,450.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,313,396.00 | 151,564,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 232,701,251.36 | 184,793,755.00 |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|---------|---|------------------|--------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 187,432,029.00 | 155,246,154.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,704,930.00 | 3,312,836.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 363,245.00 | 1,228,135.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,662,000.00 | 6,669,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,442,794.00 | 459,690.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 80,453.36 | 159,510.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 40,015,800.00 | 17,718,430.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 123,711,541.00 | 12,209,282.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,612,834.00 | 945,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 113,098,707.00 | 11,264,282.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,088,905,630.03 | 923,404,422.24 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 743,695,671.59 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 743,695,671.59 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 743,695,671.59 |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 743,695,671.59 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 233,800,546.06 | 179,405,413.50 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 119,886,201.73 | 57,763,997.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 113,914,344.33 | 121,641,416.50 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 832,842,875.97 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 832,667,875.97 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 175,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 22,262,208.00 | 303,337.15 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,262,208.00 | 303,337.15 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 26,376,197.15 | 2,741,556,862.85 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 26,072,860.00 | 2,741,860,200.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 26,072,860.00 | 2,741,860,200.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 26,072,860.00 | 2,741,860,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 26,072,860.00 | 2,741,860,200.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (26,072,860.00) | (2,741,860,200.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 303,337.15 | (303,337.15) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 303,337.15 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 303,337.15 | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-------------------------|-------------------------|--|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,652,793,695.25 | 5,471,340,444.95 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (17,909,705.08) | (17,909,705.08) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,634,883,990.17 | 5,453,430,739.87 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (60,934,070.57) | (60,934,070.57) |
| 2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,652,793,695.25 | 5,471,340,444.95 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (17,909,705.08) | (17,909,705.08) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,634,883,990.17 | 5,453,430,739.87 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (60,934,070.57) | (60,934,070.57) |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,573,949,919.60 | 5,392,496,669.30 |
| 2025 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,573,949,919.60 | 5,392,496,669.30 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,573,949,919.60 | 5,392,496,669.30 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 3,187,602,591.27 | 3,187,602,591.27 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 4,761,552,510.87 | 8,580,099,260.57 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|------------------|------------------|-----------------|--------|
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 8,745,683,500.00 | 7,805,093,537.41 | 940,589,962.59 | 89.25 |
| Татварын бус орлого | 8,745,683,500.00 | 7,805,093,537.41 | 940,589,962.59 | 89.25 |
| Нийтлэг татварын бус орлого | - | 31,128,192.00 | (31,128,192.00) | |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | - | 31,128,192.00 | (31,128,192.00) | |
| Тусламжийн орлого | 8,745,683,500.00 | 7,773,965,345.41 | 971,718,154.59 | 88.89 |
| Төсвөөс санхүүжих | 8,745,683,500.00 | 7,773,965,345.41 | 971,718,154.59 | 88.89 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,745,683,500.00 | 7,805,093,537.41 | 940,589,962.59 | 89.25 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 8,745,683,500.00 | 7,805,093,537.41 | 940,589,962.59 | 89.25 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,557,920,300.00 | 7,625,688,123.91 | 932,232,176.09 | 89.11 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,557,395,400.00 | 3,920,973,380.06 | 636,422,019.94 | 86.04 |
| Үндсэн цалин | 1,951,422,700.00 | 1,975,987,715.34 | (24,565,015.34) | 101.26 |
| Нэмэгдэл | 1,459,364,700.00 | 932,128,699.60 | 527,236,000.40 | 63.87 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 568,467,500.00 | 524,743,779.34 | 43,723,720.66 | 92.31 |
| Урамшуулал | 578,140,500.00 | 488,113,185.78 | 90,027,314.22 | 84.43 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 608,119,100.00 | 466,266,058.42 | 141,853,041.58 | 76.67 |
| Тэтгэврийн даатгал | 397,083,200.00 | 325,931,736.80 | 71,151,463.20 | 82.08 |
| Тэтгэмжийн даатгал | 52,898,500.00 | 39,021,338.33 | 13,877,161.67 | 73.77 |
| ҮОМШӨ-ний даатгал | 26,452,700.00 | 19,592,729.35 | 6,859,970.65 | 74.07 |
| Ажилгүйдлийн даатгал | 26,330,500.00 | 16,130,328.56 | 10,200,171.44 | 61.26 |
| Эрүүл мэндийн даатгал | 105,354,200.00 | 65,589,925.38 | 39,764,274.62 | 62.26 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 69,578,900.00 | 51,949,717.77 | 17,629,182.23 | 74.66 |
| Гэрэл, цахилгаан | 37,721,700.00 | 31,611,762.83 | 6,109,937.17 | 83.80 |
| Түлш, халаалт | 22,273,200.00 | 14,041,973.71 | 8,231,226.29 | 63.04 |
| Цэвэр, бохир ус | 9,584,000.00 | 6,295,981.23 | 3,288,018.77 | 65.69 |
| Хангамж, бараа материалын зардал | 102,838,800.00 | 94,502,430.66 | 8,336,369.34 | 91.89 |
| Бичиг хэрэг | 31,590,900.00 | 31,590,900.00 | - | 100.00 |
| Тээвэр, шатахуун | 3,896,400.00 | 2,681,100.00 | 1,215,300.00 | 68.81 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 26,812,400.00 | 24,852,705.94 | 1,959,694.06 | 92.69 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,017,100.00 | 1,440,000.00 | 577,100.00 | 71.39 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 38,522,000.00 | 33,937,724.72 | 4,584,275.28 | 88.10 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 27,574,100.00 | 27,574,050.00 | 50.00 | 100.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 1,759,400.00 | 1,759,400.00 | - | 100.00 |
| Урсгал засвар | 25,814,700.00 | 25,814,650.00 | 50.00 | 100.00 |
| Томилолт, зочны зардал | 162,086,100.00 | 151,564,450.00 | 10,521,650.00 | 93.51 |
| Дотоод албан томилолт | 162,086,100.00 | 151,564,450.00 | 10,521,650.00 | 93.51 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,997,909,000.00 | 2,901,593,755.00 | 96,315,245.00 | 96.79 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 235,172,200.00 | 146,646,154.00 | 88,526,046.00 | 62.36 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100.00 | - | 100.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 3,530,600.00 | 3,312,836.00 | 217,764.00 | 93.83 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 3,504,700.00 | 1,228,135.00 | 2,276,565.00 | 35.04 |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | |
|---|------------------|------------------|---------------|--------|
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,732,069,000.00 | 2,732,069,000.00 | - | 100.00 |
| Газрын төлбөр | 659,100.00 | 459,690.00 | 199,410.00 | 69.75 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 4,515,900.00 | 159,510.00 | 4,356,390.00 | 3.53 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,457,400.00 | 17,718,430.00 | 738,970.00 | 96.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 32,418,900.00 | 11,264,282.00 | 21,154,618.00 | 34.75 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,418,900.00 | 11,264,282.00 | 21,154,618.00 | 34.75 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 187,763,200.00 | 179,405,413.50 | 8,357,786.50 | 95.55 |
| Бусад урсгал шилжүүлэг | 187,763,200.00 | 179,405,413.50 | 8,357,786.50 | 95.55 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 64,326,000.00 | 57,763,997.00 | 6,562,003.00 | 89.80 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 123,437,200.00 | 121,641,416.50 | 1,795,783.50 | 98.55 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | - | - | |
| АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | - | - | |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | - | - | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 303,337.15 | (303,337.15) | |
| ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 184 | 174 | 10 | 94.57 |
| БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0 | 100.00 |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | 0 | 100.00 |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 91 | 85 | 6 | 93.41 |
| Удирдах ажилтан | 14 | 13 | 1 | 92.86 |
| Гүйцэтгэх ажилтан | 77 | 72 | 5 | 93.51 |
| ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 89 | 85 | 4 | 95.51 |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 81 | 75 | 6 | 92.59 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 10 | -2 | 125.00 |
| НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ | 3 | 3 | 0 | 100.00 |
| Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 3 | 3 | 0 | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|--------|--|-----------------|
| 1 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО | 81,919,610.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 945,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 945,000.00 |
| 120007 | Бусад орлого | 945,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 80,974,610.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 80,974,610.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 80,974,610.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 66,899,210.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 66,899,210.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 66,899,210.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 57,354,210.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 57,354,210.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,600,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,600,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 945,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 945,000.00 |
| 3 | ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 15,020,400.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ | 15,020,400.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 15,020,400.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 15,020,400.00 |
| 225101 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 15,020,400.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (15,020,400.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - |
| 9 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| 10 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь эрхэм зорилгоо “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлнэ.” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвөөс олгох хөрөнгө, нийгмийн даатгалын сангуудын зарлага, санхүүжилтийн талаар санхүүгийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн сан, банктай ажлаа уялдуулан мэдээллээр хангах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын төвлөрсөн санд улсын төсвөөс шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын санд цаг тухайд нь шилжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;
- Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр, мэдээг сар бүр гаргаж, санал, дүгнэлтийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж, танилцуулах;
- Ажил олгогч, даатгуулагчаас шимтгэлийг бүрэн төлүүлэх, тооцоо хийх, бүртгэлд тусгах, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг зохих журмын дагуу шуурхай олгох ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;
- Нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх, эсхүл эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацаанд хяналт тавьж, эрүүл мэндийн магадлалын үйлчилгээг удирдан зохион байгуулж шалган зааварлах;
- Эрдэм шинжилгээ, боловсрол, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;
- Нийгмийн даатгалын байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн сүлжээгээр хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг өргөжүүлэх, цахим тооцоолох техник хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран улсын хэмжээнд зохион байгуулах;
- Гадаад улстай байгуулсан нийгмийн даатгалын талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн орон тооны төлөвлөгөөг батлан 7.6 мянган ажил олгогч, 122.1 мянган иргэнийг албан журмын даатгалд, 23.1 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр нийт хамрагдвал зохих малчдын тоог 125.6 хувь буюу 10.7 мянган иргэнээр нэмэгдүүлсэн;
- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарлаж, өндөр өртэй аж ахуй нэгж байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, даатгуулагчдад учирч болох санхүүгийн болон нийгмийн эрсдэлийн талаар ойлгуулах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах чиглэлээр хуримтлагдсан шимтгэлийн авлага үүсгэсэн 4,760 ажил олгогчийн 32,200,000.0 мянган төгрөгийн өрийг барагдуулсан;
- Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 700,000,000.0 мянган төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэй, сар бүрийн эцэст хүү тооцох нөхцөлтэй, нэг жилийн хугацаатай

хадгалуулахаар мөнгөн хадгаламжийн гэрээг Хаан банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банкттай тус тус байгуулсан;

- Шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчийн мэдээллийг Сангийн яам, Боловсролын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, Гадаадын иргэн харьяатын газар зэрэг газруудад мэдэгдсэн;
- Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт, өмнөх шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнд төлөвлөгөөт хяналт, шаталт хийн, төвийн 5 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн нийт 31,194 аж ахуй нэгж байгууллагын нөхөн тайлан өгсөн, цалин зассан, иргэн нэмж, хассан, иргэн устгасан 17,219 шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч баталгаажуулсан;
- Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа журмын дагуу иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос авах нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг иргэний болон ажил олгогчийн портал систем /portal.ndaatgal.mn/-д байршуулсан, судалгаанд нийт 1,874 ажил олгогч, 3,492 иргэн, даатгуулагч оролцон системийн хурд, найдвартай ажиллагааг сайжруулах, техникийн алдааг багасгах, процессын шат дамжлагыг цөөлөх, программ ашиглах талаарх хэрэглэгчдэд зориулсан дэлгэрэнгүй, ойлгомжтой заавар, мэдээллийг тогтмол хүргэх зэрэг санал, хүсэлт ирүүлсэн;
- Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөрийг баталж, төлөвлөгөөнд зарим төрлийн тэтгэвэр буюу олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахаар тусгасан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Олон улсын хэлэлцээр болон бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сангийн сайдын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/3 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2025 оны “Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай А/172 дугаар тушаал;
- Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.4, 6.5-д заасны дагуу хяналт-шинжилгээ хийж, тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилт, 69 арга хэмжээ тусгаснаас хэрэгжилтийг 92.1 хувь гэж үнэлжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/362 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын шаардлагад нийцсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэн ирүүлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,187,353.9 мянган төгрөгөөр буюу 37.1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|--------------------|
| Мөнгөн хөрөнгө | 303.3 | - | (303.3) |
| Авлага | 734.2 | 734.2 | - |
| Бараа материал | 129,329.1 | 91,245.6 | (38,083.5) |
| Үндсэн хөрөнгө | 5,262,584.1 | 8,488,324.9 | 3,225,740.7 |
| Нийт хөрөнгө | 5,392,950.8 | 8,580,304.7 | 3,187,353.9 |
| Өглөг | 454.1 | 205.4 | (248.6) |
| Засгийн газрын хувь оролцоо | 5,392,496.7 | 8,580,099.3 | 3,187,602.6 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн | 5,392,950.8 | 8,580,304.7 | 3,187,353.9 |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 303.3 мянган төгрөгөөр буурсан нь Ахмадын сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл мөнгөн хөрөнгийг тайлант оны эцэст улсын төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 91,245.6 мянган төгрөг болж, 38,083.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 98,132.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 19,685.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 4,793.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 2,356.3 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 1,401.1 мянган төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, 93,178.2 мянган төгрөгийн бараа материал, 29,545.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг зарцуулснаас, мөн НДЕГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/351 дүгээр тушаалаар баталсан “Бараа материал акталж, данснаас хасах тухай”, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу хугацаа дууссан, ашиглалтгүй болсон маягт, зөвшөөрлийн хуудас бүхий 10 нэр төрлийн 109,621.0 ширхэг 20,318.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,488,324.9 мянган төгрөг болж, 3,225,740.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь:
 - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 284 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 24 нэрийн, 58,441.1 мянган төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг 23,376.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
 - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 530 дугаар тогтоолоор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 327 дугаартай магадлалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгөд бүртгэлтэй, 7,408 м.кв газар эзэмших эрхийг 4,309 м.кв болгосонтой холбогдуулан үнэлгээг 2,739 м.кв талбайн үнэлгээ болох 16,132.7 мянган төгрөгөөр бууруулан данснаас хасаж бүртгэсэн;
 - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 600 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газар, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 33 нэр төрлийн, 119,817.1 мянган төгрөгийн балансын үнэ, 119,817.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хассан;
 - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 730 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 160 нэр төрлийн, 388,091.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 131,694.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
 - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 893 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон харьяа газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23 нэр төрлийн, 37,291.6 мянган төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас хассан;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан 2025 оны “Хөрөнгийн хуваарилалт батлах тухай” А/131 дүгээр тушаалаар салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж төсөл арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуваарилагдсан 1 нэр төрлийн, нийт 728,612.5 мянган төгрөгийн үнэ бүхий 7 серверийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан 2025 оны “Хөрөнгийн хуваарилалт батлах тухай” А/146 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд нийлүүлэгдэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хуваарилагдсан, 2 нэр төрлийн, 114,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий 40 ширхэг компьютер, тоног төхөөрөмжийг бүртгэсэн;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан 2025 оны “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/209 дугаар тушаалаар 5 нэр төрлийн, 48,809.8 мянган төгрөгийн 45 ширхэг компьютер, тоног төхөөрөмжийг бүртгэсэнтэй холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 205.4 болж өмнөх оноос 248.6 төгрөгөөр буурсан нь ажиллагчидтай холбоотой НДШ-ийг төлсөнтэй холбоотой;

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,580,099.3 мянган төгрөг болж, 3,187,602.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаарх судалгааны талаар: Тус газар нь 4 нэр төрлийн нийт 2,730,188.9 мянган төгрөгийн үнэ бүхий лиценз, программ, хангамжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнээс тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 3 нэр төрлийн нийт 2,725,400.0 мянган төгрөгийн лиценз, программ, хангамжийг худалдан авах ажиллагаа зохион байгуулан худалдан авалт хийж, хөрөнгөд бүртгэсэн. Үүнд:

- Шилэн дансны автоматжуулалтын программ 17,600.0 мянган төгрөг;
- Нийгмийн даатгалын Мэдээллийн сангийн удирдлагын программ хангамжийн 2,319,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий лиценз;
- Аюулгүй байдлын мэдээлэл ба үйл явдлын удирдлагын программ хангамжийн 388,800.0 мянган төгрөгийн өртөг бүхий лиценз худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /хуучин нэрээр/ болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ай Ти Зон” ХХК-тай байгуулсан “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх” гэрээний дагуу мэдээллийн шинэ системийг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан 2,759,939.2 мянган төгрөгийн өртөг бүхий программ, хангамжийг тайлант онд хүлээн авч, Мэдээллийн технологийн төвийн хөрөнгөд бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-д заасны дагуу төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,684,216.1 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлыг 6,684,216.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/1528 дугаар албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг нийт 7,180,159.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 13,864,375.6 мянган төгрөгөөр баталжээ. Тухайлбал: Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 6,748,799.2 мянган төгрөг, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 641,025.7 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлыг 11,678.2 мянган төгрөг, Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлсний зардлыг 319,354.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Тайлант оны батлагдсан төсвийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 4,707,554.1 мянган төгрөгөөр бууруулж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 463,596.3 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 3,923,991.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 99,133.7 мянган төгрөг, зөвлөл, хороо гишүүдийн ажлын хөлсний урамшууллын зардлыг 210,152.3 мянган төгрөгөөр тус тус бууруулан тодотгож, 9,156,821.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээнд нийт 8,745,683.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,805,093.5 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,805,093.5 мянган төгрөг буюу 89.2 хувьтай байгаа нь цалин, хөлсний зардлыг 636,422.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 141,853.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 17,629.2 мянган төгрөг, томилолт, хангамж, бараа материалын зардлыг 8,336.4 мянган төгрөг, зочны зардлыг 10,521.7

мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 96,315.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 21,154.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------------|---|--------------------|--------------------|------------------|-------------|
| 71901 | Нийгмийн даатгал | 8,745,683.5 | 7,805,093.5 | 940,590.0 | 89.2 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 7,812,779.4 | 7,226,967.4 | 585,812.0 | 92.5 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 199,155.7 | 137,780.5 | 61,375.2 | 69.2 |
| 80213 | Өмгөөлөл хуулийн үйлчилгээ | 222,800.0 | 146,646.2 | 76,153.8 | 65.8 |
| 80219 | Харуул хамгаалалтын зардал | 12,372.2 | - | 12,372.2 | - |
| 80224 | Зөвлөл хороо комиссын гишүүд | 310,813.0 | 114,294.0 | 196,519.0 | 36.8 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 123,437.2 | 121,641.4 | 1,795.8 | 98.5 |
| 80813 | Хуульд заасан үндэслэлээр албан хаагчдад олгох тэтгэмж урамшуулал | 9,234.0 | 9,234.0 | - | 100.0 |
| 80820 | Бусад дэмжлэг тусламж | 55,092.0 | 48,530.0 | 6,562.0 | 88.1 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар: Улсын Их Хурлын баталсан 2024 оны “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12-д “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох” заалт, “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг тайлант онд эхлүүлсэн.

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны хязгаарыг 93 байсныг 84, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийг 7 газар, 5 хэлтэстэй байсныг 6 газар, 5 хэлтэстэй байхаар баталсан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Албан хаагчдын унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/307 дугаар тушаалаар алба хаагчдын ажлын нөхөх төлбөрийн хэмжээг нэг өдөрт буюу 35.0 мянган төгрөг буюу нэг өдрийн хоолны мөнгийг 34.0 мянган төгрөг, унааны төлбөрийг 1.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд 568,467.5 мянган төгрөгийг төлөвлөн, гүйцэтгэлээр 524,743.8 мянган төгрөгийг зарцуулан, 43,723.7 мянган төгрөгийн зардлыг дутуу зарцуулжээ.

3. Гадаад томилолт, арга хэмжээний талаар: Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээний зардал гараагүй байна.

4. Сургалт, семинарын талаар: Тайлант онд 10 сургалт, семинарын зардалд 32,418.9 мянган төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9 сургалт зохион байгуулахад 11,264.3 мянган төгрөгийг зарцуулж, 21,154.6 мянган төгрөгийн зардлыг дутуу зарцуулсан байна. Үүнд:
 1. “Төрийн албаны мэдээллийн системд чадавхжуулах” сургалтад салбарын хүний нөөцийн 86 албан хаагчийг хамруулан, танхимын түрээс, цай, усны зардалд 1,462.8 мянган төгрөг;
 2. Улсын ерөнхий прокурорын газраас “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-г танилцуулах сургалтад 97 албан хаагчийг хамруулан, цайны зардалд 576.5 мянган төгрөг;
 3. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн заах аргын “Багшлахуй” захиалгат сертификаттай сургалтад 10 албан хаагчийг хамруулан, сургалтын төлбөрт 1,300.0 мянган төгрөг;
 4. “Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт” сэдэвт сургалтад байгууллагын албан хаагчдыг хамруулахад 550.0 мянган төгрөг;
 5. “AI технологийн хөгжил болон хүний нөөцийн уялдаа” сэдэвт сургалтад 4 албан хаагчийг хамруулан, сургалтын төлбөрт 596.0 мянган төгрөг;
 6. Төрийн худалдан авах ажиллагааны А-3 мэргэшүүлэх сургалтад 11 албан хаагчийг хамруулан, сургалтын төлбөрт 990.0 мянган төгрөг;
 7. “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжлийн цахим сургалт”-д 1 албан хаагчийг хамруулан, сургалтын төлбөрт 250.0 мянган төгрөг;
 8. “Үндэсний бичгийн сургалт”-д 84 албан хаагчийг хамруулан, сурах бичиг болон сургалтын төлбөрт 4,000.0 мянган төгрөг;
 9. Орхон аймагт зохион байгуулагдсан “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтны сургалт-зөвлөгөөн”-ний цай, усны зардалд 1,539.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй байна.
6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 81,919.6 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 80,974.6 мянган төгрөгийн хандив, тендерийн бичиг баримтын хураамжаас 945.0 мянган төгрөг төвлөрч, гүйцэтгэлээр 80,974.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Иргэд, даатгуулагч, ажил олгогчдыг нийгмийн даатгалын талаарх мэдээллээр хангах зорилгоор гарын авлага хэвлэх зардалд 30,728.5 мянган төгрөг;
- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн эмхэтгэл бэлтгүүлэхэд 19,499.7 мянган төгрөг;
- Хөдөлмөрийн чадвараа түр алдасны тэтгэмжийн талаар богино видео, сайн дурын даатгалын талаар болон нийгмийн даатгалд хамрагдахыг уриалсан богино видео, болон малчны сайн дурын даатгалын талаарх богино видеоны зардалд 3,600.0 мянган төгрөг;
- Нийгмийн даатгалын танилцуулга, тараах материал хэвлэх зардалд 7,126.0 мянган төгрөг;
- Сайн дурын даатгалтай холбоотойгоор “Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж”-ийн талаарх видео контент бэлтгэх зардалд 5,000.0 мянган төгрөг;
- Нийгмийн даатгалын албан хэрэгцээнд зориулан нэг бүр нь 1,237.9 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг сканер, 1,419.0 мянган төгрөгийн 3 ширхэг принтер, 2,349.0 мянган төгрөгийн 3 ширхэг утасгүй хулгана, гар нийт 15,020.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхэд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны 2025 онд худалдан авах ажиллагааны хүрээнд 5 багц бараа ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 3,229,208.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөн “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр зохион байгуулжээ. Үүнд:

1. Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн гарын авлага, тараах материал хэвлэх, эх бэлтгэх 53,295.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, шалгарсан “Адмон принт” ХХК-тай гэрээ байгуулан, 10,000 ширхэг гарын авлага, 9,500 ширхэг багц хуулийн танилцуулга бүхий тараах материал хүлээн авч, гэрээний дагуу 30,728.5 мянган төгрөгийг олгосон;
2. Нийгмийн даатгалын сангийн 149,133,804.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулахтай холбоотой Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үйлчилгээ үзүүлэх 300,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 3 удаа зохион байгуулж, шалгарсан Дэлгэрэнгүй хууль НҮТББ-тай 198,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, гүйцэтгэлээр 121,846.0 мянган төгрөгийг олгосон;
3. Нийгмийн даатгалын байгууллагуудын албан хэрэгцээнд шаардлагатай 79,208.0 мянган төгрөгийн маягт худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэлээр 17,718.4 мянган төгрөгийг зарцуулсан;
4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын байрны засварын 50,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулан, гүйцэтгэлээр 22,410.7 мянган төгрөгийг зарцуулсан;
5. Нийгмийн даатгалын өгөгдлийн сангийн удирдлагын лиценз, программ хангамж, системийн хөгжүүлэлт хийхэд нийт 2,800,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 удаа зохион байгуулж, шалгарсан Ай Ти Зон ХХК-тай Мэдээллийн сангийн удирдлагын программ хангамжийн 2,319,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий лиценз, Аюулгүй байдлын мэдээлэл ба үйл явдлын удирдлагын программ хангамжийн 388,800.0 мянган төгрөгийн өртөг бүхий лиценз нийлүүлэх гэрээ тус тус байгуулан, нийт 2,707,800.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчилтэй асуудал гарсан:

1. Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Үүнд: Төсвийн шууд захирагчийн тушаал, шийдвэргүй, худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний хавсралт, маягтаар нийт 3,229,208.9 мянган төгрөгийг төлөвлөж, тус төлөвлөгөөнд нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь хууль, эрх зүйн үндэслэл тодорхойгүй, гүйцэтгэлээр 2,900,503.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснийг нэгтгэн тайлагнаагүй, тайлант онд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;" 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана.", Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.7-т "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;" 48.2.8-т "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;" Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 3.1-т "Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-т заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэргүй худалдан авах ажиллагааг төлөвлөсөн, нэмэлт өөрчлөлт оруулсан, худалдан авалт хийснийг холбогдох журамд заасны дагуу тайлагнаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. - Худалдан авах ажиллагаа хариуцсан албан тушаалтан нь Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж өөрийн боловсруулсан тендерийн баримтад үнэлгээний шатанд оролцсон нь шударга өрсөлдөөн, ил тод, үнэлгээний хорооны хараат бус байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлийг үүсгэсэн байна.
 - Тус байгууллага 2025 оны худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй, хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар сарын 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-т "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:, 37.13.5-т "нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;", Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-т "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаа хариуцсан албан тушаалтнаар Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллуулсан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө, жагсаалтад 4 өөрчлөлт оруулан, худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус газрын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн зарцуулалт, зардлын гүйцэтгэл, хэрэгжилт, үр дүн, үндсэн хөрөнгө, цалин хөлстэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитор Г.Өсөжаргал, аудитор Д.Номингуа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/255 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болон үйл ажиллагааны бус зардал 6,190,648.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 61,906.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 3,107,473.0 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс, 3,107,473.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах 2 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 4 мэдээллийг байршуулаагүй, зарлагын 206,969.2 мянган төгрөгийн дүн бүхий 16 гүйлгээний мэдээллийг хавсарган байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;" 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.8.2-т "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" 10 дугаар зүйлийн 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-д байгууллагын ажилтнуудын цалингийн карт, тооцооны хүснэгтийг 70 жил хадгалахаар зааж өгсөн боловч, тус байгууллага нь 10 жил хадгалах хугацаатай харилцах дансны зарлагын баримтад хавсарган архивын нэгж үүсгэсэн байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2-т "архивын баримтад нягтлан шалгалт хийх;" 23.2.4-т "архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах;" 24.1.7-т "байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг байгуулж, ажиллуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;" 25.2.4-т "хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан хэлэлцэх;" 25.2.5-т "байнга болон түр хадгалах баримт бичгийн данс бүртгэл, устгах баримтын жагсаалтыг хянан хэлэлцэх;" 25.2.6-т "баримт бичгийн хөтлөлт, бүрдүүлэлтэд үзлэг шалгалт хийх;" 24.1.9-т "архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих." Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 15.1-т зааснаас бусад үндэслэлээр мэдээллийг устгахыг хориглоно.", Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-ын 1 дүгээр хавсралтын 1.2.1-т "Нягтлан бодох бүртгэл тайлан бүлгийн 182.ажилтнуудын цалингийн тооцооны хүснэгт-70 жил НШ, 183. Ажилтнуудын цалингийн карт -70 жил НШ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн цалингийн харилцах баримтыг архивын нэгж үүсгэн тусад нь бүрдүүлээгүй архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох журмын дагуу хадгалалтыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 1:

Грийн финанс санхүүгийн тайлангийн систем нь үндсэн хөрөнгийн тайлан, бараа материалын тайланг дэлгэрэнгүй байдлаар буую хөрөнгийн өртөг, төрөл тус бүрээр орлого, зарлагыг нэгтгэсэн, дэлгэрэнгүй excel файл хэлбэрээр татагдахгүй байгаа нь санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.3.2-д "журналд бичих;", 14.3.3-д "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх;", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5-т "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн системээс шалтгаалан гарч буй бүртгэл, тайлагналтай холбоотой алдааг систем гүйцэтгэгч аж ахуй нэгжид хандан шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 2:

Төрийн аудитын байгууллагад 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-т заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-ийн 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, нэмэлт төсвийн гүйцэтгэл, хүрсэн үр дүн, тэдгээрийн танилцуулгыг бэлтгэж төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн тайлагнаж Төрийн аудитын байгууллагад ирүүлж байх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар нийт 1,027,117.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 978,142.1 мянган төгрөгийн 5 алдааг залруулах, 48,974.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 6 зөвлөмж өгсөн. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- НДЕГ-ын харьяа байгууллага Мэдээллийн технологийн төвөөр гүйцэтгүүлэх боломжтой Тэтгэврийн даатгалын сангийн тооцооллын дашбоардыг 1 иргэнээр гүйцэтгүүлж 4,800.0 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтын шаардлага хангаагүй, шууд зардлаар тайлагнасан байсан зөрчлийг арилган, давтан гаргаагүй байна.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Шагнах тухай" А/173 дугаар тушаалаар нэр бүхий 4 албан хаагчид 7,728.0 мянган төгрөгийн шагналыг зардлын эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардлаас олгосон зөрчилд жилийн эцсийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн.
- Аймаг, хот, сумдад албан томилолтоор ажилласан хоногийг 8 албан хаагчид 1,350.0 мянган төгрөгийн томилолтын олговрыг илүү тооцож олгосон байсныг тухайн 8 албан хаагчийн цалингаас буцаан суутгасан байна.

- Ерөнхий журналд бараа материалын шинжтэй нийт 8,556.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн. Үүнд: Шилэн хана 5,505.5 мянган төгрөг, шилэн хаалга 450.0 мянган төгрөг, хуулга 420.0 мянган төгрөг, Болорсофт-Монгол бичигт хөрвүүлэх багц хэрэглээний программ хангамжийн 1 жилийн эрх 1,780.0 мянган төгрөг. Жилийн эцсийн аудитаар зөрчлийг давтан гаргаагүй байна.
- Бараа материалын дансанд өмнөх онд худалдан авсан нөөцлөх шаардлагагүй 23,500.7 мянган төгрөгийн аж ахуйн материал буюу цайны материал, хугацаа дууссан ашиглалтгүй болсон маягт, зөвшөөрлийн хуудаснууд зарцуулагдаагүй үлдэгдлийг НДЕГ-ын даргын 2025 оны “Бараа материал акталж, данснаас хасах тухай” А/351 дүгээр тушаал, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2025 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийн дагуу хугацаа дууссан, ашиглалтгүй болсон маягт, зөвшөөрлийн хуудас бүхий 10 нэр төрлийн 109,621.0 ширхэг 20,318.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан байна.
- Бараа материалын дансанд 3,040.2 мянган төгрөгийн 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийн шинжтэй тавилга эд хогшил, тоног төхөөрөмж бүртгэсэн байсныг үндсэн хөрөнгийн дансанд залруулан бүртгэсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 628,655.2 мянган төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 8,421.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 17,909.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 599,931.0 мянган төгрөгийн 14 албан шаардлага, 8,421.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулж, 17,909.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------------|-----------|------------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 15 | 628,655.2 | 14 | 599,931.0 | 95.4 |
| Төлбөрийн акт | 1 | 8,421.0 | 1 | 8,421.0 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 17,909.7 | 3 | 17,909.7 | 100.0 |
| Нийт дүн | 19 | 654,985.9 | 18 | 626,261.7 | 98.5 |

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн Ахмадын сангийн хөрөнгийг санд төвлөрүүлэлгүй зарцуулсан, сангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний тайланг улирал бүр гаргаж тайлагнаагүй албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй байгаа нь өмнөх онд хариуцаж байсан албан хаагчид ажлаас чөлөөлөгдөж, тайлант онд тус зөрчилд хариуцлага тооцох албан хаагчид байхгүй тул тайлант онд шинээр томилогдсон албан хаагчдад зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Нийгмийн даатгалын мэдээллийн систем

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /хуучин нэрээр/, Нийгмийн даатгалын ерөнхий газар нь “Ай Ти Зон” ХХК-тай “Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх” гэрээг 2019 онд 2 жилийн хугацаанд гүйцэтгэхээр байгуулан, бүрэн дуусаагүй системийг салбарын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлснээс иргэн, аж ахуйн, нэгж байгууллагад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасан даатгуулагчид олгогдох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн төлөлт зэрэг асуудлуудыг хугацаа алдаж шийдвэрлэгдсэн зэрэг хүндрэлүүд үүссэн.

Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/314 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын мэдээллийн системийг хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, 12 дугаар сарын 15-ны өдөр Ай Ти Зон ХХК-иас системийн эх кодыг хүлээн авч, 2,759,939.2 мянган төгрөгийн өртөг бүхий программ, хангамжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Тайлант онд системийн хөгжүүлэлтийн хүрээнд нийт 2,707,800.0 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь системийн өртгийн үндэслэлийг мэдээллийн технологийн аудитын хүрээнд нарийвчлан шалгаж, зарцуулсан зардал нь бодит гүйцэтгэл, техникийн үр дүнтэй уялдсан эсэхийг мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн шинжээч оролцуулан гүйцэтгэлийн аудитаар хамруулан үзэх нь зүйтэй байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн шинэчлэлтэй холбоотой асуудал

Тайлант оны эцэст шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь өмнөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээс ялгагдах онцлог өөрчлөлт байхгүй бөгөөд дараагийн аудитаар өмнөх Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй харьцуулж, үнэлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,115.4 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд авлагын эцсийн үлдэгдлийг 570.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Орлого үр дүнгийн тайланд бусад орлого 945.0 мянган төгрөгийг тайлагнаагүй;
- Орлого үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,600.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан;

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27 болон санхүүгийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 156,309.2 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнд 53,382.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлж, 102,927.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 156,309.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 94,402.7 мянган төгрөгөөр их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Ахмадын сангийн батлагдсан төсвийг Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-д заасны дагуу "Ахмадын сан"-д 13,213.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй зарцуулсан;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталсан "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу сангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний тайланг улирал бүр гаргаж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх";, 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх";, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх";, 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-т "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-д "аж ахуйн нэгж, байгууллага, өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоос, төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгө";, Нийгмийн даатгалын ерөнхий газрын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталсан "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 2.1.1-т "Тухайн нийгмийн даатгалын байгууллагын жил бүрийн цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгө", 5.2-т "Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний тайланг улирал бүр баталсан маягтын дагуу гаргана", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын сангийн батлагдсан төсвийг сангийн дансаар дамжуулан зарцуулаагүй, сангийн тайланг журамд заасны дагуу тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант оны 2, 3, 4, 10 дугаар сард 24 албан хаагчид нийт 14,385.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг төсөв захирагчийн тушаал, шийдвэргүйгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэргүйгээр илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлс олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Ажилтнуудын 2025 оны 1-12 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь хувь хүний орлогын албан татварын тайлангийн дүнгээс 3,034.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, үүнээс шалтгаалан нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүнг татварын тайлангийн цалингийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин, хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээс татвар болон нийгмийн даатгалын тайлангуудын дүнг зөрүүтэй тайлагнасан, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд нэр бүхий 4 албан хаагчид нийт 7,728.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг зардлын эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ын Үндсэн цалин/211101/ заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зөв зарцуулж, дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5. Нэмэлт төсвөөс 3,713.7 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг сканер, 7,047.0 мянган төгрөгийн 3 ширхэг принтер, 4,259.7 мянган төгрөгийн 3 ширхэг утасгүй хулгана, гар, нийт 15,020.4 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бэлтгэсэн,

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/99 дүгээр тушаалд нэмэлт санхүүжилтийн төсвөөс зарцуулах холбогдох хууль, эрх зүйн үндэслэлийг тусган өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" , 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;" , 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." , Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.4-т "Төсөвт байгууллага нь нэмэлт төсөв, давсан орлого, холбогдох төсөл арга хэмжээний хүрээнд компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, программ хангамж худалдан авах тохиолдолд төсөв зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвшөөрөл олгож байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын зөвшөөрөл, шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкны эрх хүлээн авагч, Чингис хаан банкнаас авах нийт 149,133,804.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр "Дэлгэрэнгүй хууль" нийтэд үйлчлэх төрийн бус байгууллагатай 198,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" НДЕГ/20250103001 дугаартай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 121,846.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

1. Гэрээний нарийвчилсан төлөвлөгөөнд гүйцэтгэх ажилбарыг 3 үе шатанд хуваарилсан боловч гэрээний тусгай нөхцөлд төлбөрийг хэсэгчлэн төлөх хуваарийг 2 хувааж төлөхөөр боловсруулсан нь ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтийн үр дүнтэй уялдуулан санхүүжилтийг олгохоор зохицуулаагүй;
2. Гүйцэтгэгчид тус гэрээний 1 дүгээр үе шатны ажлын гүйцэтгэлийн тайлан, мэдээг ирүүлсэн байхад гэрээнд заасан төлбөрийн 50.5 хувь буюу 100,000.0 мянган төгрөгийг олгосон нь гэрээний тусгай нөхцөлд заасан төлбөр төлөх хуваарь болон нарийвчилсан төлөвлөгөөний хуваарьтай уялдуулан санхүүжилтийг олгоогүй, гэрээнд заасан хүрэх үр дүн буюу нийт барагдуулах 149,133,804.3 мянган төгрөгийн авлагаас барагдуулаагүй;
3. Тайлант онд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;" , 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" , 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" , Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." , 48 дугаар зүйлийн 48.2.7-т "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;" , 48.2.8-т "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;" , Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.1-т "Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын

хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-т заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний нарийвчилсан төлөвлөгөө болон санхүүжилт олгох хуваарийг уялдуулж төлөвлөх, ажлын гүйцэтгэлийг бодит үр дүнтэй үнэлж гэрээний төлбөрийг олгох.

Илрүүлэлт 2:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврыг зөрчин бичгийн хэрэгслийн зардалд 2,927.2 мянган төгрөгийг 12 дугаар сарын 31-ний өдөр зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны 05 дугаар "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврын 1.4.3-т тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан даалгавар болон дээд шатны байгууллагын шийдвэрийг биелүүлж, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|-------------------------------------|---|------------|----------------|-----------------------------------|----------------|--------------------------|----------------|------------|----------------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | Санхүүгийн байдлын тайланд авлагын эцсийн үлдэгдлийг 570.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 570.0 | 1 | 570.0 | - | - | 1 | 570.0 | - | - | - | - |
| | Орлого үр дүнгийн тайланд бусад орлого 945.0 мянган төгрөгийг тайлагнаагүй. | 1 | 945.0 | 1 | 945.0 | - | - | 1 | 945.0 | - | - | - | - |
| | Орлого үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,600.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан. | 1 | 1,600.4 | - | - | 1 | 1,600.4 | 1 | 1,600.4 | - | - | - | - |
| Дүн | | 3 | 3,115.4 | 2 | 1,515.0 | 1 | 1,600.4 | 3 | 3,115.4 | - | - | - | - |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | | | |
|-------------------------------------|--|--------------------------|-----------|---------------|-----|-----------------|----------|-----------------------------------|-----|---------|-----|---|-----|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | 1. Ахмадын сангийн батлагдсан төсвийг Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-д заасны дагуу "Ахмадын сан"-д 13,213.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй зарцуулсан; 2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталсан "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу сангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний тайланг улирал бүр гаргаж тайлагнаагүй. | 1 | 13,213.0 | | | 1 | 13,213.0 | | | | | | |
| | Тайлант оны 2, 3, 4, 10 дугаар сард илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлс олгохдоо 24 албан хаагчид нийт 14,385.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг төсөв захирагчийн тушаал, шийдвэргүйгээр олгосон. | 1 | 14,385.8 | | | 1 | 14,385.8 | | | | | | |
| | Ажилтнуудын 2025 оны 1-12 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь хувь хүний орлогын албан татварын тайлангийн дүнгээс 3,034.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, үүнээс шалтгаалан нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүнг татварын тайлангийн цалингийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан. | 1 | 3,034.8 | | | 1 | 3,034.8 | | | | | | |
| | Тайлант онд нэр бүхий 4 албан хаагчид нийт 7,728.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг зардлын эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардлаас олгосон байна. | 1 | 7,728.0 | | | 1 | 7,728.0 | | | | | | |
| | НДС-ийн Капитал банкны эрх хүлээн авагч, Чингис хаан банкнаас авах | 1 | 100,000.0 | | | | | | | | 1 | 100,000.0 | |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|---|---|----------|--|--|---|----------|--|--|--|--|--|
| | <p>149,133,804.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулах зорилгоор НДЕГ нь 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр "Дэлгэрэнгүй хууль" ТББ-тай 198,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх" НДЕГ/20250103001 дугаартай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 121,846.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар дараах зөрчил илэрлээ.</p> <p>Тухайлбал:- Гэрээний нарийвчилсан төлөвлөгөөнд гүйцэтгэх ажилбарыг 3 үе шатанд хуваарилсан боловч гэрээний тусгай нөхцөлд төлбөрийг хэсэгчлэн төлөх хуваарийг 2 хувааж төлөхөөр боловсруулсан нь ажлын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтийн үр дүнтэй уялдуулан санхүүжилтийг олгохоор зохицуулаагүй.</p> <p>- Гүйцэтгэгчид тус гэрээний 1 дүгээр үе шатны ажлын гүйцэтгэлийн тайлан, мэдээг ирүүлсэн байхад гэрээний төлбөрийн 50.5 хувь буюу 100,000.0 мянган төгрөгийг олгосон нь гэрээний тусгай нөхцөлд заасан төлбөр төлөх хуваарь болон нарийвчилсан төлөвлөгөөний хуваарьтай уялдуулан санхүүжилтийг олгоогүй, гэрээнд заасан хүрэх үр дүн буюу нийт барагдуулах 149,133,804.3 мянган төгрөгийн авлагаас барагдаагүй.</p> <p>-Тайлант онд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.</p> | | | | | | | | | | | |
| | <p>Нэмэлт төсвөөс 3,713.7 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг сканер, 7,047.0 мянган төгрөгийн 3 ширхэг принтер, 4,259.7 мянган төгрөгийн 3 ширхэг утасгүй хулгана, гар, нийт 15,020.4 мянган төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бэлтгэсэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/99 дүгээр тушаалд нэмэлт санхүүжилтийн төсвөөс</p> | 1 | 15,020.4 | | | 1 | 15,020.4 | | | | | |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | | |
|------------|---|----------|------------------|----------|----------|----------|-----------------|----------|----------|----------|------------------|----------|----------|
| | зарцуулах холбогдох хууль, эрх зүйн үндэслэлийг тусган өгөөгүй байна. | | | | | | | | | | | | |
| | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврыг зөрчин бичгийн хэрэгслийн зардалд 2,927.2 мянган төгрөгийг 12 дугаар сарын 31-ний өдөр зарцуулсан байна. | 1 | 2,927.2 | - | - | 5 | 53,382.0 | - | - | 2 | 102,927.2 | - | - |
| Дүн | | 7 | 156,309.2 | - | - | 5 | 53,382.0 | - | - | 2 | 102,927.2 | - | - |

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|-------------------------------------|---|--------------------------|-------------|---------------|-----|-----------------|-------------|---------|-----|--------------------------------------|-----|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Тухайлбал: Төсвийн шууд захирагчийн тушаал, шийдвэргүй, худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний хавсралт, маягтаар нийт 3,281,503.9 мянган төгрөгийг төлөвлөж, уг төлөвлөгөөнд нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан хууль, эрх зүйн үндэслэл тодорхойгүй, гүйцэтгэлээр 2,900,503.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснийг нэгтгэн тайлагнаагүй, тайлант онд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна. | 1 | 2,900,503.7 | | | 1 | 2,900,503.7 | | | | |
| | Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-д байгууллагын ажилтнуудын цалингийн карт, тооцооны хүснэгтийг 70 жил хадгалахаар зааж өгсөн боловч, тус байгууллага нь 10 жил хадгалах хугацаатай харилцах дансны зарлагын баримтад хавсарган архивын нэгж үүсгэсэн байна. | 1 | - | | | 1 | - | | | | |

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | |
|--|---|----------|--------------------|----------|----------|-----------|--------------------|----------|----------|----------|
| | <p>Худалдан авах ажиллагаа хариуцсан албан тушаалтан нь Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж өөрийн боловсруулсан Тендерийн баримтад үнэлгээний шатанд оролцсон нь шударга өрсөлдөөн, ил тод, үнэлгээний хорооны хараат бус байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн байж болзошгүй.</p> <p>- Тайлан онд тус байгууллагын Дотоод аудит, мониторингийн газраас худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй, түүний хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</p> | 1 | - | | 1 | - | | | | |
| | <p>Грийн финанс санхүүгийн тайлангийн систем нь үндсэн хөрөнгийн тайлан, бараа материалын тайланг дэлгэрэнгүй байдлаар буюу хөрөнгийн өртөг, төрөл тус бүрээр орлого, зарлагыг нэгтгэсэн, дэлгэрэнгүй excel файл хэлбэрээр татагдахгүй байгаа нь санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагыг бүрэн хангахгүй байна.</p> | 1 | - | | | | 1 | - | | |
| | <p>Төрийн аудитын байгууллагад 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэг "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-т заасны дагуу иж бүрэн ирүүлээгүй.</p> | 1 | - | | | | 1 | - | | |
| | <p>Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 4 мэдээллийг байршуулаагүй /байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нэмэлт өөрчлөлт, тайлан/, мөн зарлагын 206,969.2 мянган төгрөгийн дүн бүхий 16 гүйлгээний мэдээллийг хавсарган байршуулаагүй.</p> | 1 | 206,969.2 | | 1 | 206,969.2 | | | | |
| | Дүн | 6 | 3,107,473.0 | - | - | 4 | 3,107,473.0 | 2 | - | - |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 294 /А 0161139

Улаанбаатар хот

САГ-2026/153/АА-СМА-ТММЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

- Ахмадын сангийн батлагдсан төсвийг Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-д заасны дагуу "Ахмадын сан"-д 13,212,997.00 /арван гурван сая хоёр зуун арван хоёр мянга есөн зуун ерэн долоон/ төгрөгийг төвлөрүүлээгүй зарцуулсан;
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталсан "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-д заасны дагуу сангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний тайланг улирал бүр гаргаж тайлагнаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;", 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-т "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-д "аж ахуйн нэгж, байгууллага, өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоос, төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгө;", Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар баталсан "Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 2.1.1-т "Тухайн нийгмийн даатгалын байгууллагын жил бүрийн цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгө", 5.2-т "Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний тайланг улирал бүр баталсан маягтын дагуу гаргана", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ахмадын сангийн батлагдсан төсвийг сангийн дансаар дамжуулан зарцуулаагүй, сангийн тайланг журамд заасны дагуу тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 295 /А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/153/НА-СМА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 2, 3, 4, 10 дугаар сард 24 албан хаагчид нийт 14,385,837.73 /арван дөрвөн сая гурван зуун наян таван мянга найман зуун гучин долоон төгрөг/ төгрөгийн илүү цагийн хөлсийг төсөв захирагчийн тушаал, шийдвэргүйгээр олгосон.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэргүйгээр илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлс олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/, төсвийн мэргэжилтэн /Ц.Отгонсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-42.Docx

1526180676



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 296 /А0161139

Улаанбаатар хот

САТ-2026/153/АА-САТ-ТММЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнуудын 2025 оны 1-12 дугаар сарын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан цалингийн дүн нь хувь хүний орлогын албан татварын тайлангийн дүнгээс 3,034,782.02 /гурван сая гучин дөрвөн мянга долоон зуун наян хоёр/ төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, үүнээс шалтгаалан нийгмийн даатгалын тайлан дахь цалингийн дүнг татварын тайлангийн цалингийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй."; 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цалин, хөлсний дэлгэрэнгүй бүртгэлээс татвар болон нийгмийн даатгалын тайлангуудын дүнг зөрүүтэй тайлагнасан, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/ төсвийн мэргэжилтэн /Ц.Отгонсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.Наранчимэг
А.Цогбаяр
Б.Ариунжаргал
Г.Өсөхжаргал
Д.Номингуа

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

902981411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-42.Docx

1526180678



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 297/А0161139
САТ-2026/153/ТЛА-СМА-ТМЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Шагнах тухай" А/173 дугаар тушаалаар нэр бүхий 4 албан хаагчид 7,728,000.0 /долоон зуун долоон мянга хорин найман сая/ төгрөгийн мөнгөн шагналыг зардлын эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардлаас олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зөв зарцуулж, дотоод хяналтыг сайжруулаагүй, зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 0-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-42.Docx

1526180680



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 298/A0161139

Улаанбаатар хот

САГ-2026/153/ТГА-СМА-ТНМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Үүнд: Төсвийн шууд захирагчийн тушаал, шийдвэргүй, худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний хавсралт, маягтаар нийт 3,229,208,900.00 /гурван тэрбум хоёр зуун хорин есөн сая хоёр зуун найман мянга есөн зуун/ төгрөгийг төлөвлөж, тус төлөвлөгөөнд нийт 4 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь хууль, эрх зүйн үндэслэл тодорхойгүй, гүйцэтгэлээр 2,900,503,734.00 /хоёр тэрбум есөн зуун сая таван зуун гурван мянга долоон зуун гучин дөрвөн/ төгрөгийн худалдан авалт хийснийг холбогдох журамд заасны дагуу тайлагнаагүй, тайлант онд худалдан авах ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;" 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана.", Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.7-т "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;" 48.2.8-т "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах;" Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 3.1-т "Захиалагч тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын 2 дугаар маягтын дагуу цахим системд боловсруулж, журмын 2.7, 2.8-т заасан төлөвлөгөө батлуулах дарааллын дагуу холбогдох дээд шатны байгууллагад тухайн төсвийн жил дууссан даруйд цахим системээр тайлагнана." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэргүй худалдан авах ажиллагааг төлөвлөсөн, нэмэлт өөрчлөлт оруулсан, худалдан авалт хийснийг холбогдох журамд заасны дагуу тайлагнаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/, Дотоод аудит, мониторингийн газрын дарга /Б.Ганхуяг/, Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ө.Бодьгэрэл/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 299/А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/153/АА-СТИА-ТММЗ

Зөрчил таслан зогсоох тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт төсвөөс 3,713,700.00 /гурван сая долоон зуун арван гурван мянга долоон зуун/ төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг сканер, 7,047,000.00 /долоон сая дөчин долоон мянган/ төгрөгийн 3 ширхэг принтер, 4,259,700.00 /дөрвөн сая хоёр зуун тавин есөн мянга долоон зуун/ төгрөгийн 3 ширхэг утасгүй хулгана, гар, нийт 15,020,400.00 /арван таван сая хорин мянга дөрвөн зуун/ төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр бэлтгэсэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/99 дүгээр тушаалд нэмэлт санхүүжилтийн төсвөөс зарцуулах холбогдох хууль, эрх зүйн үндэслэлийг тусган өгөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;" 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 2.4-т "Төсөвт байгууллага нь нэмэлт төсөв, давсан орлого, холбогдох төсөл арга хэмжээний хүрээнд компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, программ хангамж худалдан авах тохиолдолд төсөв зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвшөөрөл олгож байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөв зарцуулах эрх бүхий дээд шатны байгууллагын шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/ нарт даалгав.



САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 3001/АД161139

Улаанбаатар хот

САГ-2026/153/ГДА-СГА-ТТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаа хариуцсан албан тушаалтан нь Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж өөрийн боловсруулсан тендерийн баримтад үнэлгээний шатанд оролцсон нь шударга өрсөлдөөн, ил тод, үнэлгээний хорооны хараат бус байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлийг үүсгэсэн байна.
2. Тус байгууллага 2025 оны худалдан авах ажиллагааны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй, хэрэгжилтэд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар сарын 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13-т "Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 37.13.5-т "нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;" Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-т "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагаа хариуцсан албан тушаалтнаар Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллуулсан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 301/А0161139

Улаанбаатар хот

САГ-2026/153/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 4 мэдээллийг байршуулаагүй, зарлагын 206,969,231.00 /хоёр зуун зургаан сая есөн зуун жаран есөн мянга хоёр зуун гучин нэгэн/ төгрөгийн дүн бүхий 16 гүйлгээний мэдээллийг хавсарган байршуулаагүй.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 5 дугаар зүйлийн 5.1.4-т "мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.", 6 дугаар зүйлийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;" 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.8.2-т "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 10 дугаар зүйлийн 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/, төсвийн мэргэжилтэн /Ц.Отгонсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 302/А0161139

Улаанбаатар хот

СДТ-2026/153/ӨА-СМА-ТНМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-д байгууллагын ажилтнуудын цалингийн карт, тооцооны хүснэгтийг 70 жил хадгалахаар зааж өгсөн боловч, тус байгууллага нь 10 жил хадгалах хугацаатай харилцах дансны зарлагын баримтад хавсарган архивын нэгж үүсгэсэн байна.


Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2-т "архивын баримтад нягтлан шалгалт хийх;", 23.2.4-т "архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах;", 24.1.7-т "байгууллагын баримт нягтлан шалгах комиссыг байгуулж, ажиллуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;", 25.2.4-т "хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан хэлэлцэх;", 25.2.5-т "байнга болон түр хадгалах баримт бичгийн данс бүртгэл, устгах баримтын жагсаалтыг хянан хэлэлцэх;", 25.2.6-т "баримт бичгийн хөтлөлт, бүрдүүлэлтэд үзлэг шалгалт хийх;" 24.1.9-т "архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих.", Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "15.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 15.1-т зааснаас бусад үндэслэлээр мэдээллийг устгахыг хориглоно.", Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт"-ын 1 дүгээр хавсралтын 1.2.1-т "Нягтлан бодох бүртгэл тайлан бүлгийн 182.ажилтнуудын цалингийн тооцооны хүснэгт-70 жил НШ, 183. Ажилтнуудын цалингийн карт -70 жил НШ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн цалингийн харилцах баримтыг архивын нэгж үүсгэн тусад нь бүрдүүлээгүй архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох журмын дагуу хадгалалтыг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01 - ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Б.Батжаргал/, Захиргаа, удирдлагын газрын дарга /Б.Даваахүү/, Үйл ажиллагаа хариуцсан ахлах нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн /Л.Нарантуяа/, Төсвийн мэргэжилтэн /Ц.Отгонсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Б.АРИУНЖАРГАЛ
Г.ӨСӨХЖАРГАЛ
Д.НОМИНГУА